



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК




САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ

ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШ

Улаанбаатар хот

2022 он

ГАРЬДЫН ГЭР БҮЛ



Сэдвийг амьдралд ойртуулах, ойлгомжтой болгох үүднээс Монголын мянга, мянган өрхийг төлөөлүүлэн Гарьдын гэр бүлийн гишүүдийн зохиомол дүрийг жишээнд ашиглан айл өрх бүрт тулгардаг санхүүгийн тулгамдсан асуудлыг зөв шийдвэрлэхэд туслахыг зорилоо. Та бүхэнд Гарьдын өрхийн гишүүдийг товч танилцуулъя.

Өвөө **Самбуу**
80 настай



Эмээ **Должин**
73 настай



Аав **Гарьд**
45 настай
Төрийн албан хаагч



Ээж **Алимаа**
43 настай
Гэрийн эзэгтэй



Том хүү **Тэмүүлэн**
25 настай



Бэр **Солонго**
24 настай



Дунд хүү **Тэнгис**
17 настай



Ач хүү **Хасар**
3 настай



Отгон охин **Тамир**
6 настай



1. Үнийн өсөлт ба амьжиргааны өртгийн уялдаа холбоо

Хүн аж амьдралаа зохицуулахдаа өдөр тутам мөнгөтэй холбоотой шийдвэр гаргадаг. Үүнийг санхүүгийн шийдвэр гэж нэрлэнэ. Бид санхүүгийн оновчтой шийдвэр гаргаснаар мөнгөө зөв зарцуулж, хуримтлал үүсгэн, ая таатай амьдрах боломж бүрдүүлж чадна. Гэтэл биднээс хамаарахгүйгээр өөрчлөгдөж, эргээд бидний амьдралд нөлөөлдөг хүчин зүйлс байна. Жишээ нь: Ажил эрхлэлт, улсын эдийн засгийн байдал, зээлийн хүүний түвшин, мөнгөний нийлүүлэлт гэх мэт. Эдгээрээс бидний өдөр тутмын амьдрал, амьжиргаанд хамгийн их нөлөө үзүүлдэг хүчин зүйлийн нэг нь инфляц юм.

Инфляц:

Үнийн ерөнхий түвшний өсөлтийг харуулсан үзүүлэлт юм.

Инфляцыг бид хялбараар бараа, үйлчилгээний үнийн өсөлт, мөнгөний худалдан авах чадварын бууралт гэж ойлгож болно.



Зураг 1. Инфляц

Хэрэв инфляцгүй байвал юмны үнэ өөрчлөгдөхгүй. Гэтэл инфляц өсөхөд мөнгөний худалдан авах чадвар буурч барааны үнэ өсдөг. Жишээ нь: "Атар" талхны үнэ 2021 онд 1,500 төгрөг байсан бол 2022 онд 1700 төгрөг болж 1.1 дахин өссөн байхад, мөнгөний худалдан авах чадвар харин урвуугаар 1.1 дахин буурчээ.



Зураг 2. Талхны үнийн өсөлт

Гэхдээ инфляцыг зөвхөн нэг барааны үнийн өсөлтөөр биш хүмүүсийн голлон хэрэглэдэг бараа, үйлчилгээний үнийн дундаж түвшний өсөлтөөр хэмжинэ. Бүх бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг улсын хэмжээгээр нэг бүрчлэн хэмжих боломжгүй. Иймээс хүн амын өргөн хэрэглээний гол нэрийн бараа, үйлчилгээг сонгон авч, тэдгээрийн үнийн дундаж өөрчлөлтийг тооцдог. Сонгон авсан эдгээр бараа, үйлчилгээг **ХЭРЭГЛЭЭНИЙ САГСНЫ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ** гэнэ.

Сагсны бараа, үйлчилгээ:

Айл өрхийн бүх хэрэглээг төлөөлж чадах өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн багцыг хэлнэ. Хэрэглээний сагсны бүтцийг айл өрхүүдийн хэрэглээ, түүний хэв маягт судалгаа хийсний үндсэн дээр тодорхойлдог. МУ-ын хэрэглээний сагс нийт 12 бүлгийн 373 бараа, үйлчилгээнээс бүрдэж байна.





Инфляцыг зөвхөн Үндэсний Статистикийн Хороо тооцно.
Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо

Дээрх нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийн дундаж өсөлтөөр инфляцыг хэмжинэ. Хэрэв зах зээл дээр бараа, үйлчилгээний үнэ өсөөд байвал иргэдийн амьдралд муугаар нөлөөлдөг.

Үүнийг нөгөө талаас авч үзвэл, инфляц өсөхөд айл өрхийн олж байгаа орлого буюу мөнгөнийх нь худалдан авах чадвар буурна. Жишээ нь: Инфляц 5 хувиар өсөхөд 1,000 төгрөгийн худалдан авах чадвар 5 хувиар буурна. Үүнийг талхаар зүйрлэн харуулъя.



2016 он



2022 он

Талхны 20-ний 1 нь хаачихав?

Зураг 3. Нэг мянган төгрөгийн худалдан авах чадвар

2. Инфляц хадгаламжид нөлөөлөх нь

Инфляц мөн иргэдийн хуримтлал, хадгаламжид сөргөөр нөлөөлнө. Инфляцын түвшний өсөлт хадгаламжийн хүүний өсөлтөөс давсан тохиолдолд иргэдийн хадгаламж үнэгүйдэж эхэлдэг. Хадгаламж төдийгүй бусдад бэлэн мөнгө зээлдүүлсэн тохиолдолд мөн адил үр дагаврыг авчирна. Энэ талаар иргэн Гарьдын хадгаламж дээр жишээ авч үзье.



Гарьд 45 настай.

Түүний гурав дахь хүү Тэнгис 17 настай. Дараа жил дээд сургуульд элсэн орох зорилготой бөгөөд түүний орохыг хүссэн дээд сургуулийн жилийн сургалтын төлбөр 1,000,000 (нэг сая) төгрөг байна.

Иргэн Гарьд хүүгийнхээ сургалтын төлбөрт зориулж 1,000,000 төгрөгийг нэг жилийн хугацаатай, жилийн 12 хувийн хүүтэй хадгаламжид хийв.

ГЭТЭЛ...

Жилийн дараа инфляцын түвшин 8 хувиар өссөн тул Тэнгисийн элсэн орохоор төлөвлөж байсан дээд сургууль нэг жилийн сургалтын төлбөрөө 8 хувиар нэмэгдүүжээ.

Үүний үр дүнд юу болох вэ?

Гарьдын хадгаламж жилийн дараа хүүний хамт 1,120,000 төгрөг болсон бол Тэнгисийн орохоор зорьсон дээд сургуулийн сургалтын төлбөр 1,080,000 төгрөг болж нэмэгджээ.

Жилийн өмнө нэг жилийн сургалтын төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц мөнгө Гарьдын хадгаламжид байсан. Гэтэл тэрбээр мөнгөө банкинд хадгалуулаагүй бол жилийн дараа мөнгөний үнэ цэнэ буурч, сургалтын төлбөр төлж хүрэлцэхгүй болох байжээ.

ТАНЫ СОНОРТ:

Манай улсад 1992 онд инфляцын түвшин 325.5 %-д хүрч байжээ.

3. Инфляц байх шаардлагатай юу?

Үнэ өсөх бус эсрэгээр буурах нь бизнес эрхлэгчдэд сөрөг нөлөөтэй байдаг. Учир нь ирээдүйн зарах бүтээгдэхүүнийх нь үнэ нэмэгдэхгүй, буурснаар орлого нь буурах аюултай. Энэ нь ажилчдынхаа цалин өсгөхгүй, эсвэл урамшуулал олгохгүй гэсэн үг юм. Ингэснээр ажилчид хөдөлмөрлөх сонирхолгүй болох, бүтээмж, үйлдвэрлэл буурахад нөлөөлнө.

Нөгөө талаас инфляц өндөр байх нь иргэдийн худалдан авах чадвар буурах, улмаар амьдралын түвшин муудаж, ядуурал нэмэгдэхэд түлхэц өгөх аюултай.

Тиймээс үнэ урт хугацаанд нам тогтвортой хэмжээнд өсөх нь хамгийн зохистой. Хөгжиж байгаа улсын хувьд инфляц 5-8 хувь өсөх нь хамгийн зохистой гэж үздэг. Учир нь тэнд нэг талдаа эдийн засгийн бүтээмж сайн байна, нөгөө талдаа худалдан авах чадвар хангагдана.

4. Үнэ тогтвортой байхын ач холбогдол

Инфляц нь ажилгүйдэл, ядуурал гэх мэт нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд шиг үргэлж олны анхаарлын төвд байдаг сэдэв биш бөгөөд үнэ тогтвортой үед “мартагддаг” гэж хэлж болно.



Зураг 4. Зимбабве улсын 2008 онд хэрэглэж байсан мөнгөн тэмдэгт

Үнэ тогтвортой байна гэдэг нь нийт ард иргэдэд ашигтай бөгөөд эдийн засаг тогтвортой, үр ашигтай ажиллах суурь хөрс болдог. Учир нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлт бол худалдан авч буй хэрэглэгчид, мөнгөө хадгалуулж буй хадгаламж эзэмшигчид, эсвэл хөрөнгө оруулалт хийж буй бизнесийн байгууллагууд гээд хэн бүхэнд шууд нөлөөтэй. Харин үнэ тогтворгүй үед иргэдийн бодит орлого буурах, ядуурал нэмэгдэх, нийгэмд тэгш бус байдал даамжрах г.м. олон сөрөг үр дагавар бий болдог.


Үнэ тогтворгүй үед юу үүсэх вэ?

- ❁ Зимбабве улсад 2008 онд эдийн засгийн болон мөнгөн тэмдэгтийн гүн хямрал болж үнийн өсөлт 231 сая хувьд хүрч, 100 триллионы мөнгөн дэвсгэрт гүйлгээнд гаргахад хүрч байв. Үүгээр гипер инфляц иргэдийн худалдан авах чадварт хэрхэн нөлөөлж, эдийн засгийг сүйрүүлдэгийг харж болно.
- ❁ Мөнгөн хуримтлалыг богино хугацаанд үнэ цэнэгүй цаас болгон хувиргах хурдтай үнийн өсөлт нь банк санхүүгийн системийг хэрхэн тогтворгүй болгодгийг 2019 онд Аргентин Улсад инфляц 57%-д, Венесуелд 39000%-д тус тус хүрснээс харж болно.
- ❁ Инфляц хасах утгатай буюу бүтээгдэхүүний үнэ өсөх биш харин буурч, "Дефляц"-тай байх үед компаниуд зардлаа бууруулахын тулд хөрөнгө оруулалтаа танах, ажиллах хүчээ цомхотгох замаар эдийн засаг агшдаг болохыг Японы сүүлийн 30 жилийн түүхээс харж болно.

Үнэ тогтворгүй, савлагаатай байхын зовлонг Монголчууд ч амсаж туулсан бөгөөд 90-ээд оны эхэнд инфляц 300% давж, жилийн дотор үнэ 3 дахин өсөхөд иргэдийн хэрэглээ, худалдан авах чадвар, хэтэвч дэх мөнгөнд ихээхэн халгаатай дарамт учирч байсан билээ.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ВАЛЮТЫН ХАНШ




1. Валют гэж юу вэ?

Валют:


Гадаад, дотоод төлбөр тооцоонд хэрэглэгдэж байгаа аль нэг улсын мөнгөн тэмдэгтийг хэлнэ.

ВАЛЮТ

Үндэсний валют:

 Тухайн улсын албан ёсны мөнгөн тэмдэгт. Монгол Улсын хувьд "Төгрөг".

Гадаад валют:

 Гадаад улс орны эрх бүхий байгууллагаас гаргасан мөнгөн тэмдэгтийг хэлнэ.



Зураг 1. Валютын ангилал

2. Валютын ханш гэж юу вэ?

Валютын ханш:

Аль нэг улсын валютыг өөр нэгэн улсын валютаар илэрхийлсэн үнэ юм. Өөрөөр хэлбэл тухайн улсын нэгж валют өөр улсын валютын хэдэн нэгжтэй тэнцэхийг харуулдаг үзүүлэлт юм.

Жишээ нь: АНУ-ын 1 ам.доллар = 2854 төгрөг гэх мэт.



Зураг 2. Ханш гэж юу вэ?

Валютын ханш буюу гадаад валютын үнэ уг валютын эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдоно.

Жишээлбэл, гадны орон руу аяллаар явах үед хэрэглээний бараа бэлэг дурсгалын зүйлс, хоол хүнс, зочид буудлын төлбөр бусад бүтээгдэхүүн худалдан авахад гадаад валют зайлшгүй хэрэг болдог. Энэ нь гадаад валютын эрэлтийг бий болгож буй нэг жишээ юм. Монгол Улсад гадаадын жуулчид ирж ам.доллар эсвэл евро зэрэг гадаад валютаа солиулан бараа бүтээгдэхүүн худалдан авч байгаа нь эсрэгээрээ валютын нийлүүлэлтийг нэмэгдүүлж буй жишээ болно.



ТАНЫ СОНОРТ:



1990 онд Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжин орсон.

Зах зээлийн эдийн засаг гэдэг нь бараа, үйлчилгээний үнэ чөлөөт үнийн системийн дагуу тодорхойлогддог эдийн засгийг хэлнэ.

Валютын ханшийн хөдөлгөөн ямар байхад тухайн улсын **валютын ханшийн дэглэм** чухал нөлөөтэй. Валютын ханшийн дэглэм нь доорх 3 төрөл байдаг.

ТОГТМОЛ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Валютын тогтмол ханшийн дэглэмийн үед тухайн улсын Төв банк үндэсний валютын бусад улсын валюттай харьцах ханшийг тогтмол түвшинд барих бөгөөд үүний тулд Төв банк нь гадаад валютын хангалттай нөөцтэй байх шаардлагатай.

Давуу тал:

- Валютын ханш тогтмол байх тул тодорхой бус байдал багатай
- Импортын барааны инфляцын дарамт харьцангуй бага

Сул тал:

- Мөнгөний бодлогын бие даасан байдал алдагддаг.
- Төлбөрийн тэнцэл зах зээлийн зарчмын дагуу тэнцвэрждэггүй.

ЧӨЛӨӨТЭЙ ХӨВӨГЧ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Чөлөөтэй хөвөгч ханшийн дэглэмийн үед Төв банк үндэсний валютын ханшийг зах зээлд чөлөөтэй хэлбэлзэж байхыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд төв банк валютын захад оролцдоггүй.

Давуу тал:

- Төв банк мөнгөний бодлогоо эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх боломжтой.
- Төлбөрийн тэнцэл зах зээлийн зарчмын дагуу тэнцвэржих нөхцөл бүрдэнэ.

Сөрөг тал:

- Валютын зах зээлд огцом хэлбэлзэл бий болох эрсдэлтэй.
- Валютын ханш суларснаар импортын барааны инфляцын дарамтыг нэмэгдүүлдэг



ЗОХИЦУУЛАЛТАЙ ХӨВӨГЧ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэмийн үед валютын ханш валютын эрэлт, нийлүүлэлт буюу валютын урсгалаар тодорхойлогдох боловч валютын захад ханшийн огцом хэлбэлзэл бий болсон үед Төв банк хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор гадаад валют худалдах, худалдан авах байдлаар зах зээлд оролцдог.

Давуу тал:

☸ Зах зээлийн ханшийн өөрчлөлтөд дасан зохицох, хүлээлтийг удирдах боломжийг олгосноор ААН-үүд үйл ажиллагаагаа тогтвортой удирдан явуулах нөхцөлийг бүрдүүлдэг.

☸ Мөнгөний бодлого эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлд үр дүнтэй хэрэгжих боломжтой.

Сөрөг тал:

☸ Төв банк тодорхой хэмжээгээр гадаад валютын нөөцтэй байж, түүнийгээ тухай бүр зах зээлд нийлүүлэх шаардлагатай.

1. Ханш гэж юу вэ?

Ханш = Валютын үнэ

2. Валютын үнийг юу тогтоодог вэ?

Эрэлт > Нийлүүлэлт
Үнэ өснө

Эрэлт < Нийлүүлэлт
Үнэ буурна

3. Эрэлт, нийлүүлэлтийг юу шийддэг вэ?

Нийлүүлэлт
Орох урсгал + Хүлээлт

Эрэлт
Гарах урсгал + Хүлээлт

ТАНЫ СОНОРТ:




Монгол Улсын хувьд 1992 он хүртэл тогтмол ханшийн дэглэмтэй байжээ. Харин 1996 онд Төв банкны тухай хууль батлагдсанаар Монгол Улс зохицуулалттай хөвөгч ханшийн тогтолцоотой болсон. Өөрөөр хэлбэл валютын ханш эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр тодорхойлогдох нөхцөл бүрдсэн.



3. Валютын ханшид нөлөөлдөг хүчин зүйлс

Валютын ханш нь маш олон хүчин зүйлсээс хамаардаг. Үүнд валютын эрэлт, нийлүүлэлт болон ханшийн талаарх олон нийтийн хүлээлт шууд байдлаар нөлөөлнө.



Зураг 3. Валютын ханшид нөлөөлдөг хүчин зүйлс

Валютын ханш нь маш олон хүчин зүйлсээс хамаарч тогтддог бөгөөд тэдгээрийг эвлүүлдэг пазлтай зүйрлүүлж болно



Эрэлтийн хүчин зүйлс

Иргэд, ААН-ийн орлого өссөнөөр тэдгээрийн худалдан авах чадвар нэмэгдэж тэр хэрээрээ дотоодод болон гадаадад үйлдвэрлэсэн бараа үйлчилгээг худалдан авах эрэлт нэмэгдэнэ.

Жишээлбэл, гадаадад аялах эсвэл шинэ машин оруулж ирэх үед иргэд гадаад валют худалдан авах шаардлагатай болдог. Нөгөөтээгүүр гадаадаас орж ирсэн гар утсыг төгрөгөөр бид авдаг ч гэлээ, тэр утсыг оруулж ирэхэд гадаад валютаар төлбөр төлсөн байдаг. Тиймээс бараа, үйлчилгээ, аялалын төлбөрт зориулан гадаад валют худалдан авахдаа иргэд валютын эрэлтийг үүсгэж буй гэдгийг санах хэрэгтэй.

Ижил төрлийн импортын бүтээгдэхүүний үнэ буурснаар дотоодод үйлдвэрлэсэн барааг импортын бараагаар орлуулан валютын эрэлтийг нэмэгдүүлнэ.

Жишээлбэл, импортын гурил, Монголд үйлдвэрлэсэн гурилын аль алийг хэрэглэдэг хүмүүсийн хувьд импортын гурилын үнэ буурахад уг гурил ижил чанартай ч үнийн хувьд дотоодод үйлдвэрлэсэн гурилаас хямд болох тул импортын гурилын борлуулалт нэмэгдэнэ. Улмаар уг гурилын борлуулалт нэмэгдэж байгаа тул тус гурилыг худалдан авахад зарцуулах буюу гадагшаа гаргаж буй валютын хэмжээ нэмэгдэнэ.

Нийлүүлэлтийн хүчин зүйлс

Нийлүүлэлтэд Монголоос гадагш худалдаалж буй экспортын бараа, үйлчилгээний орлого, нөгөө талаас Монголд орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалт, зээл зэрэг багтдаг.

Жишээлбэл, Манай улсын хөрөнгө оруулалт, засаглалын орчин тогтвортой сайн байвал Монголд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэх ба улмаар энэ нь Монгол Улс руу чиглэх валютын урсгалыг өсгөнө. Энэ утгаараа хууль, эрх зүйн орчин цаашлаад хөдөлмөрийн бүтээмж, тухайн улсын өрсөлдөх чадвар гэх мэт үзүүлэлтүүд нь валютын нийлүүлэлт нэмэгдэхэд дам байдлаар нөлөөлдөг.

Дээр дурдсан эрэлт болон нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөөгөөр валютын ханш нь байнга хэлбэлзэж байдаг байна.

**ТАНЫ СОНОРТ:****Монголбанк валютын зах зээлд хэрхэн оролцдог вэ?**

Санхүүгийн зах зээлд цочрол үүсгэх мэдээлэл гарах, үйл явдал тохиолдоход зах зээлд оролцогчид сандралд орох, улмаар бүгд нэгэн зэрэг эзэмшиж буй валютаа зарах, эсвэл гадаад валют худалдан авах гэх мэт үйлдэл хийдэг бөгөөд энэ нь зах зээл дэх эрэлтийг огцом нэмэгдүүлэх эсвэл бууруулах замаар банк, санхүүгийн тогтолцоог тогтворгүй болгох, компаниуд дампуурах зэрэг эрсдэл дагуулдаг. Иймд богино хугацааны шинжтэй энэ мэт өөрчлөлтөөс сэргийлж зах зээлийг хэвийн ажиллуулах нөхцөлөөр хангахын тулд зарим тохиолдолд Төв банкнаас валютын захад оролцож үүссэн нөхцөлийг зөөлрүүлэх эдийн засаг, санхүүгийн системд тогтворгүй байдал үүсэхээс сэргийлэхэд анхаардаг. Монголбанкнаас зах зээл дэх илүүдэл эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийг авах, валютын ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор гадаад валютын дуудлага худалдааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагуудад явуулдаг.

Хүлээлт

Богино хугацаанд валютын ханшийн хөдөлгөөнд эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсээс гадна зах зээлд оролцогчдын хүлээлт нөлөөлдөг.

Жишээлбэл, Японоос машин худалдаж авах гэж буй Бат, гадагшаа их сургуулийн төлбөрөө төлөх гэж буй Дорж ойрын хугацаанд ам.долларын ханш буурч, төгрөгийн ханш чангарна гэж бодож байгаа бол Бат, Дорж хоёр гадагш төлөх валютаа өнөөдөр худалдан авахгүй аль болох ам.долларын ханш хямдрахыг хүлээнэ.

Эсрэгээрээ өөрийн урласан ноолууран хувцсыг Европын зах зээлд нийлүүлдэг Цэцэгээ төгрөгийн ханш чангарна гэж үзэж байгаа бол борлуулалтын орлогоос олсон валютаа цаг алдалгүй худалдан төгрөгт хөрвүүлэхийг бодно.

Энэ мэтчилэн зах зээлд оролцогчдын хүлээлтээс шалтгаалан гадаад валютын эрэлт, нийлүүлэлт өөрчлөгдөж байдаг тул богино хугацаанд валютын ханшид хүлээлтийн хүчин зүйлс нөлөөлдөг. Оновчтой, зөв хүлээлт бүрэлдэхэд зах зээлийн мэдээллийг баттай эх сурвалжаас шуурхай авах, түүнийг боловсруулах чадвар чухал.

4. Валютын ханшийн өөрчлөлт бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?



Банк болон Банк бус санхүүгийн байгууллага

Харилцагчдынхаа валютын эрэлт, нийлүүлэлтийн хэмжээнд үндэслэн валютыг худалдах, худалдан авах өөрийн ханшийг тогтооно.



Монголбанк




Валютын зах дээр арилжааны банкуудын худалдсан, худалдаж авсан гадаад валютын арилжааны дундаж ханшийг зарладаг. Монголбанкнаас зарласан ханшийг шүүх, гаалийн тооцоо болон нягтлан бодох бүртгэлд ашиглана.

Зураг 4. Валютын ханшийг хэн зарладаг вэ?

ХАНШ ТОГТООХ

Банк, ББСБ нь өөрсдийн ханшийг тогтооно.



Зориулалт:

-  Гадаад валют худалдаж авах
-  Гадаад валют зарах
-  Хэлцлийн ханш

ХАНШ ЗАРЛАХ

Монголбанк нь банкуудын ажилжааны дундаж ханшийг тооцож, зарлана.

Зориулалт:

-  Нягтлан бодох бүртгэл
-  Гааль, шүүх, татвар, шимтэл, хураамж, төлбөр ноогдуулах



ВАЛЮТ	ВАЛЮТЫН НӨР	АЛБАНХАНИ	АВАХ	ЗАЛАХ	АВАХ	ЗАЛАХ
USD	Америкийн доллар	2354.74	2355.00	2355.00	2355.00	2355.00
EUR	Евро	3349.32	3371.00	3336.00	3371.00	3366.00
CNY	Утгадагчын юань	455.38	475.90	474.90	475.90	474.90
RUB	Оросын рубль	36.88	36.28	37.48	36.48	37.48
JPY	Японы иен	27.04	26.78	27.22	26.78	27.22
GBP	Английн фунт	3477.08	3470.00	3720.00	3470.00	3720.00
CHF	Швейцарчын франк	3183.08	3205.00	3170.00	3205.00	3170.00
HKD	Гонконгийн доллар	246.34	246.10	246.80	246.10	246.80
INR	Индийн рупий	2.45	2.36	2.39	2.45	2.39
KWD	Кувейтийн динар	3463.34	3463.00	3463.00	3463.00	3463.00
THB	Тайландын бат	2146.61	2177.00	2177.00	2146.61	2177.00
SGD	Сингапурчын доллар	2325.04	2326.00	2377.00	2326.00	2377.00
MYR	Малайзын ринггит	1285.08	1285.00	1285.00	1285.00	1285.00
KAZ	АКТ	174289.36	174289.84	174289.84	174289.84	174289.84
UAH	Украины гривна	2152.74	2274.11	2274.11	2274.11	2274.11



AFG	Афганистанын доллар	2,854.74
BYN	Беларусын рубль	1,349.32
BYR	Японий иен	2704
CHF	Швейцарчын франк	3,183.08
CHF	Швейцарчын франк	3,183.08
CHF	Английн фунт	3,477.08
CHF	Бразилийн реал	1,712.40
CHF	Унгарчын форинт	9.25
CHF	Египетчын фунт	181.31
CHF	Эстониачын евро	36.85
CHF	Хонгконгийн динар	368.34

Зураг 5. Ханш тогтоох, ханш зарлах



Валютын ханшийн өөрчлөлт бараа, үйлчилгээний үнээр дамжин иргэдийн амьжиргаанд нөлөөлдөг. Хэрэв гадаад валютын ханш өсвөл гадаадад худалдаж буй экспортын барааны үнэ, гаднаас авч буй импортын барааны үнэ нэмэгдэнэ. Хялбар жишээ бодож үзье.

Хүснэгт 1. Ханшийн өөрчлөлтийн үнэд үзүүлэх нөлөө

Хугацаа	Ам.долларын ханш	Барааны нэр	Ам.доллаар илэрхийлсэн үнэ	Төгрөгөөр илэрхийлсэн үнэ
2021-01-01	2849	1 кг чихэр	2 ам.доллар	5,698 төгрөг
2021-01-01	2849	1 кг чихэр	2 ам.доллар	5,698 төгрөг
2021-01-01	2849	1 ш ноолууран цамц	50 ам.доллар	142,450 төгрөг
2021-01-01	2849	1 ш ноолууран цамц	50 ам.доллар	142,450 төгрөг

Дээрх жишээнээс үзэхэд барааны хэмжээ, төрөл, гадаад зах зээлээс худалдан авсан үнэ өөрчлөгдөөгүй байна. Гэтэл долларын ханш өссөнөөс шалтгаалан төгрөгөөр илэрхийлсэн чихрийн үнэ буюу хэрэглээний зардал, ноолууран цамцны үнэ буюу үйлдвэрлэлийн орлого аль аль нь өссөн байна. Энэ мэтчилэн гадаад валютын ханшийн өөрчлөлт валютаар худалдан авдаг бүх бараа, үйлчилгээний үнэд нөлөөлдөг. Үүнээс үзвэл валютын ханш өссөнөөр импортын хэрэглээний зардал өндөр болох тул энэ үед орлуулан хэрэглэж болох эх орны үйлдвэрийн бараагаар хэрэгцээгээ хангавал валютын ханш өссөн ч хэрэглээний зардал нэмэгдэхгүй байх боломжтой. Ийнхүү хэрэглэгчдийн хувьд барааны үнэ өөрчлөгдөхөд үүнд тохируулан барааны сонголтоо уян хатан хийдэг байх нь бараа бүтээгдэхүүний үнэ зах зээлд үр ашигтай, бодитой тогтоход чухал ач холбогдолтой.

Харин эсрэгээрээ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гадны зах зээлд борлуулж буй компанийн орлого валютын ханш өсөхөд нэмэгддэг. Нөгөө талаас экспортлогч компани эсвэл гадагшаа их хэмжээний бараа экспортолдог улсын хувьд валютын ханш өсвөл бүтээгдэхүүнийх нь үнэ өсч борлуулалт буурах эрсдэлтэй байдаг.



5. Валют хаанаас худалдан авах вэ?

Бага дүнтэй валютыг арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, валют арилжааны төвүүдээс тухайн өдрийн самбарын ханшаар авах боломжтой.

Жишээлбэл, Та АНУ-д сурч буй дүүдээ 1000 ам.доллар шилжүүлэх хэрэгтэй болсон гэж бодъё. 1000 ам.долларыг банкнаас худалдаж аваад, түүнийгээ шилжүүлж болно. Эсвэл үүнээс арай бага ханшаар бэлэн валютын захаас валютаа худалдан авч, түүнийгээ банкаар дамжуулан шилжүүлж болно.

Харин их хэмжээний валют худалдан авах, эсвэл зарах хэрэгтэй бол та ямар ханшаар худалдах вэ?


Барааны бөөний болон жижиглэнгийн үнүүд ялгаатай тогтдогийн адил банк ч мөн өндөр дүнтэй валютын арилжаа хийхдээ ханшийг самбарын ханшаасаа ялгаатайгаар харилцагчтайгаа харилцан тохирдог.


Тэгвэл их дүнтэй ийм арилжаанууд ямар ханшаар хийгдэж байгааг та хэрхэн мэдэх вэ?

Их хэмжээтэй арилжааны хувьд мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан иргэд, аж ахуйн нэгжүүд ямар ханшаар их дүнтэй арилжаа хийхээ мэддэггүй. Мөн нэгдсэн мэдээллийн сангийн улмаас өндөр дүнтэй валютын арилжаа хийх гэж буй этгээд арилжаа хийхийн тулд банкуудтай нэг бүрчлэн холбогдож мэдээлэл авах шаардлагатай болдог нь цаг хугацаа алддаг сөрөг талтай.

Иймд зах зээл дэх мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, валютын захын дэд бүтцийг сайжруулах зорилгоор Монголбанк банк хоорондын валют арилжааны цахим талбарыг 2017 оны 4 дүгээр сард ашиглалтад оруулсан. Ингэснээр банк хоорондын өндөр дүнтэй валютын арилжаа хэдий хэмжээгээр, ямар ханшаар хийгдэж буй мэдээллийг нээлттэй түгээж эхэлсэн. Мөн өндөр дүнгээр валютын арилжаа хийх этгээд нь өөрийн харилцагч банкаар дамжуулан уг талбарт оролцон арилжааг шуурхай хийх боломжтой болсон.







Бидний тухай | Мөнгөний бодлого | Валютын зах | Санхүүгийн тогтвортой байдал | Төлбөрийн систем | Статистик

Банкны хяналт шалгалт / **СМА / МУТСТ**

Статистик НУУР / СТАТИСТИК / ХАНШИЙН СТАТИСТИК

Мөнгө, санхүүгийн статистик Буцах

Гадаад секторын статистик

Банк хоорондын цахим талбарын валют арилжаа


Хэрэглээний үнийн статистик /ХУИ/	Огноо	Жигтэсэн дундаж ханш (USD)	Арилсан хэмжээ (USD)	Жигтэсэн дундаж ханш (CNY)	Арилсан хэмжээ (CNY)
Сүүлийн сарын бичлэгийг харах бол энд дарна уу					


Банк хоорондын цахим талбарын валют арилжааны ханш *


Алт, мөнгөний үнэ	Огноо	Авах (USD)	Зарах (USD)	Авах (CNY)	Зарах (CNY)
Төв банкны үйл ажиллагааны статистик	2020/09/14 14:30	-	2856.00	-	-
	2020/09/14 12:30	-	2856.00	-	-
	2020/09/14 11:30	-	2856.00	-	-
Засгийн газрын үнэт цаас	2020/09/14 10:30	-	2856.00	-	-
Дамжуулан олгох төслийн зээл	2020/09/11 16:30	2854.00	2856.50	-	-
	2020/09/11 15:30	2854.00	2856.50	-	-
	2020/09/11 14:30	2854.00	2856.50	-	-
Статистик мэдээлэл тархаах хуваарь	2020/09/11 12:30	-	2858.00	-	-
	2020/09/11 11:30	-	2858.00	-	-
	2020/09/11 10:30	-	-	-	-
	2020/09/10 16:30	2854.00	2855.70	-	-
	2020/09/10 15:30	2854.00	2857.00	-	-
	2020/09/10 14:30	2854.00	2857.00	-	-


* Тухайн үед цахим талбарт идэвхитэй байгаа валют худалдах, худалдан авах саналын ханш


Цахим талбарын танилцуулга товхимлыг энд дарж үзнэ үү.



Инфляцийн мэдээлэл


Цахим талбарын валютын ханш


Монголбанкнаас зарласан ханш


Зээлийн мэдээллийн сан


Эдийн засгийн энгийнээр


Активын чанарын үнцгээ

ТАНЫ СОНОРТ:

Валютын зах зээлийн статистик мэдээллийг Монголбанкны цахим хуудасны гадаад секторын статистик цэсний Төлбөрийн тэнцлийн тайлан, Гадаад худалдааны тойм, Гадаад өрийн тайлан, Гадаад секторын тойм, Гадаадын хөрөнгө оруулалтын позиц зэрэг тайлангаас үзэх боломжтой. Дээрх тайлан, мэдээнүүд нь валютын зах зээлд үүссэн нөхцөл байдлыг бодитой дүгнэх, валютын ханшийн талаарх ирээдүйн хүлээлтээ зөв тодорхойлоход өндөр ач холбогдолтой юм.